



VERTALING MONGOOLS

“Centrum voor Leerlingenbegeleiding” (CLB) – Сурагчдад чиглэл өгөх төв - 7 асуулт хариултаар

1 CLB гэж юу вэ? CLB нь Сурагчдад чиглэл өгөх төв юм. Фландэрсийн бүх сургууль ийм төвтэй хамтран ажилладаг. CLB бүрт эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, сурган хүмүүжүүлэгчдээс бүрдсэн баг ажилладаг. Тус баг нь сургуультай хамтран таны хүүхдийг мэдлэг, авьяас, чадвараа аль болох их хөгжүүлэх боломжоор хангадаг.

2 Би ч бас CLB-д хандаж болох уу? Мэдээж тэгэлгүй яахав. Эцэг эх, багш нар, болон хүүхэд, өсвөр насныхан өөрсдөө шууд хандан мэдээлэл, тусламж, чиглэл авч болно. Зарим CLB соёл хоорондын харилцаа эрхэлсэн ажилтантай ба тэр нь өөр соёл зан заншилтай хүмүүсийн харилцааг хөнгөвчилдөг.

3 Би CLB-д ямар төрлийн асуудлаар хандаж болох вэ?

- Хэрэв танай хүүхэд унших, бичих, суралцах, судлах бэрхшээлтэй бол;
- Хэрэв танд хичээлийн сонголт, сургалтын боломж, гэрчилгээ, дипломын талаар асуух зүйл байгаа бол;
- Хэрэв танай хүүхэд сургууль дээрээ тав тухгүй байдаг бол: дарамт, муу сурахаас айх айдас, дээрэлхэх, догшин зан төлөв, сургууль завсардах;
- Хэрэв танай хүүхэд эрүүл мэндийн асуудалтай байвал: вакцинжуулалт, өсөлтийн асуудал, хар тамхины хэрэглээ, таргалалт г.м.

4 CLB хэрхэн ажилладаг вэ? Хэрэв танд асуулт буюу асуудал байвал, эхлээд сургуультай энэ талаар ярилцсан нь дээр. Ихэнх тохиолдолд багш “zorgleeraar” (засах багш) буюу эрхлэгч танд тусалж чадна. Гэвч заримдаа CLB-д очих шаардлага гардаг. CLB-ийн зөвлөх таны асуултыг шалгаж, тантай хамт шийдлийг хайдаг. Заримдаа CLB танай хүүхдийг нэмэлт сорилтод оруулна. Эс бөгөөс зарим үед асуудал нь илүү нарийн мэргэжлийн тусламж хэрэг болохоор өргөн хүрээтэй байх нь бий. Энэ учир шалтгааны улмаас CLB бүх төрлийн үйлчилгээ, мэргэжилтэнтэй ойр хамтран ажилладаг: суралцах бэрхшээлийг эмчлэх төвүүд, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, сэргээн засах эмчилгээний төвүүд г.м.

5 Манай хүүхэд CLB-ийн эрүүл мэндийн үзлэгт орох ёстой юу? Тиймээ, Фландэрсийн хүүхэд бүр цэцэрлэгийн хоёр дахь жил, бага сургуулийн тав дахь жил, дунд сургуулийн гурав дахь жилээ CLB-ийн эрүүл мэндийн үзлэгт орох ёстой. Энэ нь заавал тавигддаг шаардлага юм. CLB-ийн эмч танай хүүхдийн нүд, чихийг үзэж, өндөр, жинг нь хэмждэг. Эмч мөн танай хүүхдийн шүд, төрх байдлыг үзэж, хэвийн өсөж байгаа эсэхийг тогтоодог. Ингэснээр эмч өвчнийг эрт үе шатанд нь шуурхай илрүүлж, муудахаас сэргийлж чадна. Хэрэв сургуулийн эмч асуудал илрүүлэх буюу сэжиглэвэл, таныг мэргэжилтнээр илүү нарийн үзлэг шинжилгээ хийлгэхийг зөвлөдөг. Эмч мөн танай хүүхдийн вакцинжуулалтыг хянадаг. Хэрэв CLB-ийн эмчид хүүхдээ үзүүлмээргүй байвал өөрийн эмчээр үзлэг хийлгэж болно. Танай эмч мөн ижил үзлэг шинжилгээ хийгээд үр дүнг нь CLB-ийн эмчид илгээнэ.

6 CLB-ийн үйлчилгээнд би төлбөр төлөх ёстой юу? Үгүй, CLB-ээс танай хүүхдэд үзүүлж буй дэмжлэг, чиглэл үнэ төлбөргүй юм.

7 CLB-ийг би хаанаас олох вэ?

- CLB-ийн зөвлөхийн харилцах мэдээлэл сургуулийн танилцуулгад мэдээж байна.
- CLB-ийн ажилтнууд мөн сургууль дээр ажилладаг цагтай байдаг нь олонтаа.
- CLB-ийн төв рүүгээ оч. Хичээлийн өдөр бүр энэ төв нээлттэй байна. CLB-ийн ажилтнууд мөн сургуулийн амралтаар тодорхой өдрүүдэд ажилладаг.

Энэ текст нь “Het CLB in 15 vragen” (“CLB 15 асуулт хариултаар”) танилцуулгын товч хураангуй юм. Тус танилцуулгыг энгийн холланд хэлээр бичсэн. Магадгүй та энэхүү богино орчуулгын тусламжтай холланд хэл дээрх текстийг унших гэж оролдож болно. Хүүхдийн хүмүүжил, боловсролыг зөвхөн сургууль дээр олгодоггүй. Та холланд хэл сурмаар байна уу? www.huizenvanhetnederlands.be вэбсайтаас хороололдоо сурч болох газрыг олох буюу хүүхдийнхээ сургууль дээрээс асуу.